

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2011 оны 02 сарын 23

дугаар 45

Улаанбаатар хот

“Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйл
ажиллагааны зохицуулалтын журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралт

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 6.2-Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос банк, түүний хараат болон охин компанид Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгох, уг үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хороо нь банк, түүний хараат болон охин компанид Банкны тухай хуулийн 6.2-т заасан дараах тусгай зөвшөөрөл олгож болно:

1.2.1. санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх,

1.2.2. итгэлцлийн үйлчилгээ,

1.2.3. даатгалын зуучлагч,

~~1.2.4. андеррайтерын үйлчилгээ~~ /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

1.2.5. кастодиан,

1.2.6. факторингийн үйлчилгээ,

~~1.2.7. харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ.~~ /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

~~1.3. Энэ журмын 1.2.4, 1.2.5 д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг банкинд олгож болох боловч уг хоёр үйл ажиллагааг нэг банк хавсран эрхлэхийг хориглоно.~~ /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/

1.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12.1.1-д тодорхой хязгаарлалт тогтоосон тул энэ журмын 1.2.1, 1.2.2, 1.2.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг банкны хараат болон охин компанид олгож болох бөгөөд тус компани нь энэ журмын 1.2-т заасан бусад үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хориглоно.

1.5. Энэ журмын 1.2.3, 1.2.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг банк, түүний хараат болон охин компанид олгож болно.

1.6. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 12.4-т тодорхой хязгаарлалт тогтоосон тул даатгалын компанийн зэрэгцээ банк, түүний хараат болон охин компанид даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй. 51-нээс дээш хувийг тус бүр эзэмшдэг нэг хувь нийлүүлэгчтэй компаниудыг зэрэгцээ компани гэнэ.

~~1.7. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 25.5-д тодорхой хязгаарлалт тогтоосон тул энэ журмын 1.3-т заасны дагуу кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк, түүний хараат болон охин компанид үнэт цаасны зах зээл дээр брокер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй. / Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

1.8. Банкны хараат болон охин компани нь энэ журмын 1.2-т заасан үйл ажиллагааг Банкны тухай хуулийн 6.1-т заасан Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аливаа үйл ажиллагаатай хавсран эрхлэхийг хориглоно.

1.9. Кастодианы үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг Хорооноос баталсан тусгай журмаар зохицуулна.

1.10. Энэ журмаар зохицуулагдаагүй харилцааг тус тусын харилцааг зохицуулсан хууль, Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.

1.11. Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ гэдэгт дараах ажил үйлчилгээг ойлгоно: */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 115 дугаар тогтоолоор нэмсэн./*

~~1.11.1. Үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах, /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

1.11.2. Хорооны 2008 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх тухай түр журам”-д заасан ажил үйлчилгээ,

1.11.3. Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа,

1.11.4. Хорооноос тогтоосон бусад ажил үйлчилгээ

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага

2.1. Энэ журмын 1.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх банк, түүний хараат болон охин компани нь эрхлэн гүйцэтгэх гэж буй үйл ажиллагааны төрлөөс хамааран дараах нөхцөл шаардлагыг хангасан байна:

2.1.1. санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, итгэлцлийн үйлчилгээ, факторингийн үйлчилгээ эрхлэхэд Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2 дахь хэсэгт заасан нийтлэг шаардлагыг хангасан байхаас гадна итгэлцлийн үйлчилгээ эрхлэхэд Хорооны 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам”-ын 5 дахь хэсэгт заасан, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэхэд Хорооны 2011 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 22 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний журам”-ын 4.1-д заасан,

~~2.1.2. андеррайтерын үйлчилгээ эрхлэхэд Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 2.1 дэх хэсэгт зааснаас гадна андеррайтерын үйл ажиллагаа эрхлэх тусгай нэгжтэй байна. /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

~~2.1.3. брокерийн үйл ажиллагаа эрхлэхэд Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 2.1, 2.5.2, 2.5.3-т заасан. /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2011 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 12 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./ /Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

2.1.4. даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.17-2.23-т заасан шаардлагыг тус тус хангасан байна.

2.2. Энэ журмын 1.2.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь тухайн тусгай зөвшөөрлийн хүрээнд үзүүлэх үйлчилгээ, эрхлэх үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрийг явуулах төлөвлөгөө, журмыг боловсруулж Хороонд ирүүлнэ.

2.3. Банкны хараат болон охин компани энэ журмын 1.2-т заасан үйл ажиллагааг энэ журамд заасны дагуу хавсран эрхлэх тохиолдолд үйл ажиллагаа тус бүрээр дүрмийн сан бүрдүүлнэ.

2.4. Факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банкны хараат болон охин компани нь толгой компани болох банк, түүний хараат болон охин компаниас факторингийн гэрээний үндсэн дээр муу актив /чанаргүй зээл/-ыг шилжүүлэн авахыг хориглоно.

~~2.5. Андеррайтерийн үйлчилгээ эрхлэхийг хүссэн банкны хувьд эредлийн сангийн хэмжээг анх 30 сая тогрөгөөр тогтоох ба цаашид андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тухай бүрд нь эредлийн сангийн хэмжээг Хороо тогтооно./Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 159 дүгээр тогтоолоор нэмсэн/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

~~2.6. Банкны андеррайтерийн үйл ажиллагааны эредлийн сангийн мөнгөн хөрөнгийг өөр банкинд нээсэн тусгай дансанд байршуулна./Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах Хорооны 2011 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 159 дүгээр тогтоолоор нэмсэн/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичиг

3.1. Банк, түүний хараат болон охин компани нь тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

3.1.1. санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, итгэлцлийн үйлчилгээ, факторингийн үйлчилгээ эрхлэхэд Хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.3-д зааснаас гадна санхүү, хөрөнгө оруулалтын

чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэхэд Хорооны 2011 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 22 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний журам”-ын 4.2-т заасан,

~~3.1.2. андеррайтерийн болон брокерийн үйл ажиллагаа эрхлэхэд Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журмын 3 дугаар зүйлд заасан./Энэ заалтад Санхүүгийн зохицуулах Хорооны 2014 оны 08 дугаар сарын 06-ний өдрийн 277 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулан/~~ *Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

3.1.3. даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.24-т заасан баримт бичгийг тус тус бүрдүүлнэ.

3.2. Банк, түүний хараат болон охин компани нь энэ журмын 3.1-д заасан баримт бичгээс гадна дараах баримт бичгийг нэмж ирүүлнэ:

3.2.1. банкны тухай хуулийн 6.4-т заасны дагуу банкинд болон түүний хараат болон охин компани байгуулах замаар мөн хуулийн 6.2-т заасан үйл ажиллагаа эрхлэхэд татгалзах зүйлгүй болох талаар Монголбанкны Ерөнхийлөгчөөс Санхүүгийн зохицуулах хороонд хандаж ирүүлсэн албан бичиг,

3.2.2. тусгай зөвшөөрөл хүсэгч нь банк бол өөрийн, банкны хараат болон охин компани бол толгой компани болох банкны сүүлийн 3 жилд Монголбанкнаас тогтоосонзохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж ажилласан тухай санхүүгийн дэлгэрэнгүй мэдээлэл,

3.2.3. банкны тухай хуулийн 6.3-т заасны дагуу банк, түүний хараат болон охинкомпани Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ Монголбанкинд хүргүүлэхдээ хавсаргаж хүргүүлсэн баримт бичгийн нэг хувь,

~~3.2.4. Банк андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүний бүтэц, хувьцаа эзэмшигчийн талаарх Монголбанкны тодорхойлолт./Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах Хорооны 2011 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 159 дүгээр тогтоолоор нэмсэн/~~ *Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/*

3.3. Банкны тухай хуулийн 6.4-т заасан Монголбанкны Ерөнхийлөгчийн албанбичиггүй болон түүний албан ёсны хуулбаргүй, эсхүл уг бичиг Хороонд ирээгүй байхадтусгай зөвшөөрөл хүсч Хороонд хандсан тохиолдолд ирүүлсэн баримт бичгийг хүлээнанавахгүй.

3.4. Тусгай зөвшөөрөл хүсч Хороонд анх удаа хандахаасаа өмнө МонголбанкныЕрөнхийлөгчийн тухайн тусгай зөвшөөрлийг олгоход татгалзах зүйлгүй болох тухаймэдэгдсэн албан бичгийг заавал авсан байна.

3.5. Банкны хараат болон охин компанид тусгай зөвшөөрөл олгоход татгалзахзүйлгүй болох талаар Хороонд мэдэгдсэн Монголбанкны Ерөнхийлөгчийн албан бичигтавахыг хүссэн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл тус бүрийг нэг бүрчлэн дурьдсан байна.

3.6. Хэрэв 2 ба түүнээс дээш үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах бол баримтбичиг бүрдүүлэхдээ тухайн харилцааг зохицуулж буй хууль, журмын дагуу үйлажиллагааны төрөл тус бүрээр тусгай зөвшөөрлийн баримт бичгийг бүрдүүлнэ.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

4.1. Хороо банкны хараат болон охин компаниас ирүүлсэн баримт бичгийн хүлээнавснаас хойш энэ журам болон тухайн төрлийн үйл ажиллааг зохицуулж буй хууль журамдзаасан шаардлагыг хангасан гэж үзвэл тусгай зөвшөөрөл олгоно.

4.2. Банк, түүний хараат болон охин компанийн ирүүлсэн бичиг баримт хууль, энэжурам болон холбогдох бусад журамд заасан шаардлага хангаагүй бол Хороо тусгайзөвшөөрөл олгохоос татгалзана.

~~4.3. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх банкны хувьд Хорооны “Үнэт цааснызах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 4.12, 4.13 дахь заалтууд хамаарахгүй./Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах Хорооны 2011 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 159 дүгээр тогтоолоор нэмсэн/ — /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 406 дугаар тогтоолоор хүчингүй болгосон/~~

Тав. Хяналт шалгалт

5.1. Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.4-д заасны дагуу энэ журмын 1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан банк, түүний хараат болон охин компанийн холбогдох хууль тогтоомж, тэдгээртний цүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, шийдвэрийн биелэлт болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ.

5.2. Хороо энэ журмын 5.1-т заасан хяналт, шалгалт хийхдээ шаардлагатай гэж үзвэл Монголбанкт хамтран нэгдсэн шалгалт хийнэ.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журмын 1.2-т заасан үйл ажиллагаа эрхэлж буй банк, түүний хараат болох охин компани, тэдгээрийн албан тушаалтан Үнэт цаасны зах зээлийн тухай, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль зөрчсөн бол Хорооны улсын байцаагч тухайн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---